



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 06 сарын 28 өдөр

Дугаар А/510

Булган сум

Г Газар эзэмших эрхийн гэрчилгээний Г  
хугацаа сунгах тухай

Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 37 дугаар зүйлийн 37.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны IX/19 дүгээр тогтоолоор баталсан “Булган сумын хөгжлийн шинэчилсэн ерөнхий төлөвлөгөө”-г тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Иргэн Ц.Жамъянсүрэн (ТЭ66103172)-гийн Булган сум 6 дугаар баг Залуус 9 дүгээр гудамж 9036 тоотод байршилтай 6308002883 нэгж талбар бүхий амины орон сууц зориулалтаар эзэмшиж буй 642 м<sup>2</sup> газрын газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг 15 жилээр, М.Батзул (ГЭ70090516)-ын Булган сум 5 дугаар баг Хатанбаатар С.Магсаржав 2 дугаар гудамж 250 тоотод байршилтай 6308003622 нэгж талбар бүхий худалдаа үйлчилгээний зориулалтаар эзэмшиж буй 548 м<sup>2</sup> газрын газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг 7 жилээр тус тус сунгасугай.

2.Ц.Жамъянсүрэн, М.Батзул нарт Булган сумын шинэчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа явуулахыг танилцуулж, газар эзэмшүүлэх гэрээг шинэчлэн байгуулж, гэрчилгээжүүлэн газар эзэмшилтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

3.Газрыг зориулалтын дагуу зүй зохистой эзэмшихийг иргэн Ц.Жамъянсүрэн, М.Батзул нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

6323010518